



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.11.29 № 03/6818
танай _____-ны № _____-т

Санал авах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 24/08 дугаар тогтоолоор "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлагдсан.

Хөтөлбөрийн үндсэн бодлого агаарын бохирдол, авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн бөгөөд Улаанбаатар "20 минутын хот" үзэл баримтлалын дагуу иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд нийслэлд хэрэгжүүлэх томоохон төсөл арга хэмжээг баталсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" гэж орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичиг байна" гэж заасан.

Иймд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.8.4 дэх заалтад заасан зарчмыг баримтлан хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг шаардагдах төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан зорилтот болон хүрэх түвшинг тодорхойлсон нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөөний саналыг боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 23-ны дотор sanal.hbth@gmail.com цахим хаягаар болон албан бичгээр ирүүлнэ үү.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах хүснэгтийг хавсаргав.

Хавсралт ³² хуудастай.

ДАРГА



П.ХАДБААТАР

1110206432



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 24/08

Улаанбаатар хот

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

2.2.Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.3.Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнах;

3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, Хурлын Хороодод даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

1110101020

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн
24/08 дугаар тогтоолын хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын хүрээнд томоохон 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км урт Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

2.Буянт-Ухаа спорт цогцолбороос 120 мянгатын уулзвар, Сүхбаатарын талбай хүртэл 13.1 км урттай болон Ард Аюушийн өргөн чөлөө, Их тойруу Намъянжүгийн гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урттай "Тусгай замын автобус" /BRT/ төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

3.Зунжин худалдааны төвөөс Сүхбаатарын талбай хүртэл 20.4 км урт "Улаанбаатар хөнгөн галт тэрэг" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

4.Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт "Агаарын дүүжин замын тээвэр" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

5."Шинэ тойрог зам", "Туулын хурдны авто зам" барих төслүүдийг эхлүүлнэ.

6.Сэлбэ дэд төв, Баянхошуу дэд төвд төрийн болон нийгмийн бүх үйлчилгээг хүртээмжтэй авах боломжтой нэгдсэн төлөвлөлттэй 20'000 өрхийн цогцолбор хорооллыг байгуулна.

7."Туул усан цогцолбор" төслийг хэрэгжүүлэн үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, гадаргын 125'000 м3/хоног хүчин чадалтай эх үүсвэр барих бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

8.Дулааны II, III цахилгааны станцыг өргөтгөн шинэчлэх, эсхүл дулаан эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгож нийслэлд шинээр ашиглалтад орох орон сууцны хорооллыг дулаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

9.Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг 600 МВт болгон өргөтгөнө.

10.Багануур дүүрэгт 50 МВт буюу 200 МВт/цаг батарей хуримтлуурын станц барих бүтээн байгуулалтын ажлыг дуусгана.

11.Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн лагийг хатаах, шатаах байгууламжийг ашиглалтад оруулна.

12. 15-20 МВт хүчин чадалтай хог шатаах үйлдвэр байгуулна.

НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Улаанбаатар "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хорооллыг хөгжүүлж иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.

Улаанбаатар "20 минутын хот"

1.1. Улаанбаатар "20 минутын хот" үзэл баримтлалын дагуу иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.

1.1.1. Хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд нэгдсэн дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчныг сайжруулна.

1.1.2. "Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж батлуулна.

1.1.3. "Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний дагуух хот байгуулалтын бусад баримт бичиг, салбаруудын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

1.1.4. Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэхэд чиглэсэн сангуудыг байгуулж, хөрөнгө оруулалт татах замаар сангуудын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.

Олон төвт хот

1.2. Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна.


1.2.1. Нийслэл Улаанбаатар хотод шинээр байгуулах орон нутгийн зэрэглэлтэй Хан-уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-Эх, Баянзүрх, Амгалан хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 42 нэгж хорооллыг хөгжүүлэх ажлыг эхлүүлж, "Нэг төвт хотоос олон төвт хот"-ын тогтолцоог бүрдүүлнэ.

1.2.2. Багануур дүүргийг уул уурхай, хүнд, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий аж үйлдвэрийн, Налайх дүүргийг хүнс, хөнгөн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, үйлчилгээ, ачаа тээврийн логистик төв бүхий аж үйлдвэрийн улсын зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

1.2.3. "Налуу-Ухаа" барилгын материал, хүнд хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистикийн, "Агросити" хүнсний нарийн ногоо, хүлэмжийн аж ахуйн кластер бүхий эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

1.2.4. "Шинэ Зуунмод" хотыг Нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагуул хот болгон хөгжүүлнэ.

1.2.5. Дамбадаржаа, Дэнжийн мянга, Толгойт, Шархад, Яармаг дэд төвүүдийн инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.



1.2.6. Шархад, Дамбадаржаа, Толгойт дэд төвүүдийг орон сууцжуулах төслийг эхлүүлнэ.

1.2.7. "Улаанбаатар хотын орлогод нийцсэн 712 айлын ногоон орон сууц төсөл"-ийг үргэлжлүүлж, "Баянголын ам түрээсийн орон сууцны хороолол барих төсөл"-ийн барилга угсралтын ажлыг дуусгана.

1.2.8. "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан"-г байгуулж, дэд төвүүдэд ногоон орон сууцны төслүүдийг хэрэгжүүлнэ.

1.2.9. Шинэ суурьшлын бүсүүдэд орон сууцны төслүүдийг хэрэгжүүлнэ

1.2.10. Хотын хөгжлийн индексийн суурь анхдагч мэдээллийн боловсруулалтыг сайжруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

1.2.11. Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг хангахад чиглэсэн хотын стандартыг батлан мөрдүүлнэ.

1.2.12. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн хангагдсан орон сууцны хорооллыг барьж, 13'280 өрхийн орон сууцыг ашиглалтад оруулна.

1.2.13. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулж, 800 өрхийн орон сууцыг стандартын шаардлагад нийцүүлнэ.

1.2.14. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах төслийн хүрээнд чөлөөлсөн газрыг нийтийн хэрэгцээнд авч авто зам өргөтгөн, ногоон байгууламж, амралт зугаалгын бүс шинээр бий болгоно.

1.2.15. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийнэ.

1.2.16. Барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд үнэлгээ хийж, паспортжуулан хүчитгэлийн зураг төслийг боловсруулна.

1.2.17. Алслагдсан гэр хороололд хэсэгчилсэн болон бие даасан дэд бүтцийн хангамжийг нэвтрүүлж, амины орон сууцны хороолол, газар шинэчлэн зохион байгуулах хэлбэрээр гэр хорооллын бүсийн орчин нөхцөлийг сайжруулна.


1.2.18. Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй ногоон санхүүжилтийн шаардлагад нийцсэн бие даасан инженерийн шийдэлтэй загвар хорооллыг төр хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж ногоон пассив барилгад шилжих өрх, аж ахуйн нэгжид ногоон орон сууцны зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

1.2.19. Гэр хороолол, дэд төв, дагуул хотуудад орон сууц барьсан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ.

1.2.20. Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.21. Нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, хамгаалан нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай болон цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бүхий газрын хэмжээг нэмэгдүүлнэ.

1.2.22. Цагдаа, түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагаа шуурхай хүрэх, нэвтрэх боломжийг бүрдүүлж гэр хороолол болон зуслангийн бүсийн орц гарц, орон



сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийг арилгана.

1.2.23.Төлөвлөлтийн дагуу баригдаагүй орон сууцны хотхон, хорооллыг дахин шинэчилж, авто зогсоол, ногоон байгууламж, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.24.Улаанбаатар хотын газар зүйн мэдээллийн системд суурилсан хот байгуулалтын "Хотын нэгдсэн мэдээллийн дата төв"-ийг байгуулан нээлттэй ашиглана.

1.2.25."Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем"-д нэмэлт хөгжүүлэлт хийнэ.

Инженерийн дэд бүтэц

1.3.Инженерийн дэд бүтцийн бодлогын баримт бичиг боловсруулж, эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлж, төвлөрөл ихтэй хэсгийн шугам сүлжээг нэгдсэн байдлаар хонгилын системд шилжүүлэх замаар тасралтгүй найдвартай байдлыг ханган иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

1.3.1.Багануур дүүрэгт 400 МВт-ын дулааны цахилгаан станц, Багануур-Улаанбаатар чиглэлийн 130 км 220 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих төслийг эхлүүлнэ.

1.3.2.Улаанбаатар дэд станцын хүчин чадлыг 2x200 МВА болгон тоноглон шинэчлэх, Парк, Дамбадаржаа, Баянхошуу, Их наран дэд станц, 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1.3.3.Цахилгаан хангамжийн түгээх сүлжээг шинэчилж, шинээр хуваарилах байгууламж, дэд өртөө барьж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр хангана.

1.3.4.Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг тархмал хэлбэрээр гэр хороололд суурилуулах төслийг хэрэгжүүлнэ.


1.3.5.Дулаан хангамжийн гол болон орон сууцны хорооллын төвлөрсөн шугам сүлжээ, насос станцыг өргөтгөн шинэчилж, шинээр барьж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.6.Сэлбэ болон Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд хийн түлшний 93МВт хүчин чадал бүхий дулааны станцыг төвлөрсөн сүлжээтэй хосолмол ажиллагаатай нөхцөлөөр ашиглалтад оруулж, орон сууцны 7 дугаар хороолол болон Дэнжийн мянга дэд төвийн дулаан хангамжийг шийдвэрлэнэ.

1.3.7.Төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн тархмал эх үүсвэр болон алслагдсан суурьшлын бүсүүдэд дулааны станцуудыг үе шаттайгаар барина.

1.3.8.Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг барьж, дулааны хүчин чадлыг 216 МВт-аар нэмэгдүүлэх төсөлд дэмжлэг үзүүлнэ.

1.3.9 Хийн түлшний эх үүсвэрээр ажиллах дулааны хэсэгчилсэн эх үүсвэр барих, одоо ашиглагдаж байгаа уурын зуухнуудыг хийн түлшний эх үүсвэрт шилжүүлэх, гэр хорооллын утаагүй шахмал түлшний хэрэглээг үе шаттайгаар хийн түлшинд шилжүүлэх замаар дулаан хангамжийг шийдвэрлэж агаарын бохирдлыг бууруулна.



1.3.10. Үерийн эрсдэлийн хохирлын үнэлгээг боловсруулж, голуудын эргийн хамгаалалт 30 км далан, 100 км суваг, 4 байршилд усан сан, хөв, цөөрөм, 20 км хөрсний ус зайлуулах шугам сүлжээг барьж байгуулан үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

1.3.11. Шинээр болон өргөтгөн шинэчлэх 257 км авто зам, замын байгууламжийг ус зайлуулах сүлжээтэй барьж байгуулан усанд автдаг байршлуудын тоог бууруулна.

1.3.12. Үер, усны эрсдэлтэй бүсийг тогтоож, үүнд өртөж байгаа гэр хорооллын айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлж чөлөөлөх, хөрсний усны нэвчилттэй байшин барилгуудын суурийн хийцлэлд хүчитгэсэн хамгаалалтыг хийх, голын ай сав газрын дагуу ус зайлуулах нэгдсэн сүлжээнд холбох, шүүрүүлэх худаг байгуулах зэрэг инженерийн шугам хоолойн нэгдсэн шийдэл гаргаж иргэдийн аюулгүй орчин амьдрах нөхцөлийг сайжруулна.

1.3.13. “Хурын усны менежментийг сайжруулж, үерийн эрсдэлээс сэргийлэх дижитал нэгдсэн хяналт, удирдлагын төв” байгуулж, ашиглалт, үйлчилгээ болон үерийн үед ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулна.

1.3.14. Ундны усны эх үүсвэрийн бүсийн дэглэмийг мөрдүүлж, Баруун эх үүсвэрийг ашиглалтад оруулна.

1.3.15. Ус хангамжийн шугам сүлжээг нэмэгдүүлэх, шинээр 4, төвлөрөл их 6 байршлын усан сан өргөтгөх, зөөврийн ус түгээх барилгуудыг төвлөрсөн сүлжээнд холбон ухаалаг төхөөрөмж суурилуулах замаар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.16. Ус хангамжийн шугамыг зэс хоолойгоор хийх тооцоо судалгааг боловсруулан үе шаттай хэрэгжүүлж, шуудуу ухалгүй доторлон шинэчлэх ажлыг үргэлжлүүлж, дэвшилтэт техник технологийг хөгжүүлнэ.

1.3.17. Гүний худгуудыг тоолууржуулах, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, зөөврийн ус түгээх барилгуудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулан усны алдагдлыг бууруулж, хэрэглээг нэмэгдүүлнэ.


1.3.18. Улаанбаатар хотын Шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, Морингийн цэвэрлэх байгууламжийг өргөтгөх ажлыг эхлүүлэн хот бүрд зөөврийн бохир ус “Юүлэх станц” барьж цэвэрлэх байгууламжуудын найдвартай ажиллагааг хангана.

1.3.19. Хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, цэвэрлэсэн усыг дулааны станц болон бусад зориулалтаар дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

1.3.20. Дагуул хот, гэр хорооллын бүсэд хэсэгчилсэн цэвэрлэх байгууламж, шугам сүлжээг барьж, Туул-1, Толгойт, Орбит, Цайз зэрэг коллектруудыг ашиглалтад оруулж, Улаанбаатар хотын Бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.21. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг нэгдсэн хяналт, удирдлага, зохицуулалтаар хангах нэгжийг байгуулж, “Бохир усны шугам хоолойн засвар үйлчилгээ, удирдлага, шинэчлэлтийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэн удирдлага, зохицуулалтыг сайжруулна.

1.3.22. Мэдээлэл холбооны нэгдсэн төвийг шинэ суурьшлын бүс, дэд төвүүдэд байгуулж, төрийн үйлчилгээг цахимжуулах суурь дэд бүтцийг бүрдүүлнэ.



1.3.23. Мэдээлэл холбооны худаг, сувагчлалын байгууламжийг өргөтгөн шинэчлэх, алслагдсан суурьшлын бүсүүдийг холбосон худаг, сувагчлалын байгууламжийг барьж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.24. Гол гудамж дагууд технологийн бус суурилуулсан шилэн кабелийг худаг сувагчлалын байгууламжид шилжүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1.3.25. Насжилт өндөртэй дэд өртөө, гэрэлтүүлгийн байгууламжийн шугам тоноглол, хяналтын удирдлагын системд өргөтгөл шинэчлэл, иж бүрэн засвар хийж, өмчлөл, эзэмшил ашиглалтыг сайжруулна.

Авто зам

1.4. Авто замын сүлжээ төлөвлөлтийг сайжруулан, авто замын хүртээмжийг нэмэгдүүлж түгжрэлийг бууруулна.

1.4.1. “Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, Наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламж барих” төслийг хэрэгжүүлнэ.

1.4.2. Хотын хөдөлгөөний эрчим их гол гудамж замуудын уулзваруудад олон түвшний огтлолцол барих ажлыг эхлүүлнэ.

1.4.3. Гудамж, авто замуудыг нэгдсэн цогц төлөвлөлтөөр 6 байршилд 27.2км замыг барьж байгуулна.

1.4.4. Авто замын гүүрэн байгууламж 5, нүхэн гарц 4 байршилд, үндсэн сүлжээ, гол, туслах гудамж 107 км замыг шинээр барьж, 150 км замыг өргөтгөн шинэчилнэ.

1.4.5. Уулзваруудад хөдөлгөөн зохион байгуулалт хийх замаар шинэчлэн сайжруулж, 1231 км гудамж замд засвар арчлалт хийнэ.

1.4.6. Явган хүн, моторт бус тээврийн хэрэгслийн замын сүлжээг нэмэгдүүлж, зорчих хөдөлгөөний нөхцөлийг сайжруулна.

1.4.7. Зорчилт хөдөлгөөнтэй уялдсан моторт бус тээврийн хэрэгслийн зогсоолыг оновчтой байршилд байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.4.8. Замын хөдөлгөөний удирдлагын төвийн системд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, гэрлэн дохионы зохицуулалтыг нэгдсэн ухаалаг системээр зохицуулна.


1.4.9. Авто зогсоолуудын нэгдсэн бүртгэл, төлбөрийн ухаалаг системийг нэвтрүүлж, тээврийн хэрэгслийн газар дээрх, доорх, автомат олон давхар зогсоолуудыг дэвшилтэт техник, технологи хөгжүүлэх замаар шинээр барьж авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4.10. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг орчимд авто замын аюулгүй байдлыг хангасан цогц төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Нийтийн тээвэр

1.5. Иргэдийн эрэлт, хэрэгцээнд суурилсан үйлчилгээний чанар, хүртээмж, найдвартай байдлыг хангах замаар хувийн авто машины хэрэгцээг багасгаж, нийтийн тээврээр зорчих зорчилтыг нэмэгдүүлнэ.

1.5.1. Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ.



1.5.2. Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолын чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж салбарын чадавхыг бэхжүүлнэ.

1.5.3. Цахилгаан автобусны цэнэглэх саравч зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулж, цахилгаан автобусны хэрэглээг нэмэгдүүлнэ

1.5.4. Төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлийн хүрээнд хотын такси тээврийг хөгжүүлж, менежментийг сайжруулна.

1.5.5. Хотын зүүн, баруун хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн бөөний худалдааны төв байгуулна.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хот төлөвлөлт, хүн амын өсөлттэй уялдуулан нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Эрүүл мэнд, биеийн тамир

2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж болон спортын барилга байгууламжийн хүртээмжийг тус тус нэмэгдүүлнэ.

2.1.1. Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

2.1.2. Нийгмийн эрүүл мэндийг төвүүдийг үе шаттайгаар байгуулж, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар амьдралын зөв дадал, хэвшлийг бий болгож, урьдчилсан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагалдыг 10 хувиар нэмэгдүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийг бууруулна.

2.1.3. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулж, эмчилгээний хамрагалдыг 98 хувьд хүргэж, товлот дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна.


2.1.4. Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.

2.1.5. Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2.1.6. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.7. Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлж, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын түвшний суурь үзүүлэлтийг 5 хувиар өсгөнө.

2.1.8. Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэж, суурь үзүүлэлтийг 5 хувиар ахиулна.



2.1.9. Нийслэлийн иргэдийн 15 хувь нь оршин суух газраасаа 20 минут алхаж хүрэх зайд ногоон байгууламж бүхий спортын цогцолборыг бий болгох, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, спортын барилга байгууламжийн хүртээмжийг 1000 хүнд 70 м²-т хүргэж нэмэгдүүлнэ.

Боловсрол

2.2. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, суралцагчийн хөгжлийг бүх талаар дэмжинэ.

2.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгыг шинээр барих, өргөтгөх замаар цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг бууруулна.

2.2.2. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын ашиглалт, ачааллын коэффициентийг 0.04-өөр бууруулна.

2.2.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, суралцагчдын суралцах нөхцөлийг сайжруулна.

2.2.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн их засвар, дулаан техникийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлж, сургалтын орчныг сайжруулна.

2.2.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг суурь түвшнээс 4 хувиар ахиулна.

2.2.6. Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг бүх талаар дэмжин ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхдийн хөгжил, хамгааллын үнэлгээг суурь түвшнээс 2.4 хувиар ахиулна.

2.2.7. Бүс нутгийн онцлог, суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төрөлжсөн ахлах сургуулийн тоог нэмэгдүүлнэ.

2.2.8. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч англи хэлийг эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх, дижитал шилжилт, технологийн өөрчлөлттэй уялдуулан роботын боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2.9. Багшийн гурван тулгуурт бодлогын хүрээнд орон нутгийн онцлогт тулгуурлан "Сайн багшийг таны дэргэд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.10. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангана.


2.2.11. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн нэмэлтээр олгож, хүүхдийн ясны бүтэц, өсөлт хөгжлийг дэмжих "Сүү" хөтөлбөрийг хамтын санхүүжилтээр хэрэгжүүлнэ.

2.2.12. Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг урамшуулах, нийгмийн баталгааг хангахад төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран дэмжлэг үзүүлнэ.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт

2.3. Бүсийн хөгжлийн зорилттой уялдуулан зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.

2.3.1. Ажил эрхэлдэггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамруулж, амьдралын зөв дадал хэвшилд сургах, ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлж орлоготой болоход нь дэмжлэг үзүүлнэ.



2.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог олон улсын стандартад нийцүүлэн өөрчилнө.

2.3.3. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

2.3.4. Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтэд дэмжлэг үзүүлнэ.

2.3.5. Оюутан, залуучуудыг цагаар хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.6. Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий тусгай бүс, төрөлжсөн байршлуудад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах бичил, жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин ажлыг байрыг нэмэгдүүлнэ.

2.3.7. Нийслэлийн хэмжээнд ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

Соёл урлаг

2.4. Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.

2.4.1. Түүх соёлын өвийг бүртгэлжүүлж, түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтад авч, засварлан тохижуулж, соёл, амралт, аялал жуулчлалын бүс болгон соёлын аялал жуулчлалыг дэмжинэ.

2.4.2. Гандантэгчинлэн хийд орчмыг тохижуулж "Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар" агуулгаар хөгжүүлж, "Буддын шашны соёлын өвийн цогцолбор" болгоно.

2.4.3. Улаанбаатар хотын музей, Улаанбаатар театр, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын төв өргөөг засварлан тохижуулж, олон нийтийн тав тухтай үйлчлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.4. Шинээр байгуулагдах хотуудад соёлын орон зай бүхий соёл, урлагийн олон төрөлт үйлчилгээтэй төвүүдийг бий болгож хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.5. Соёл, спорт, аялал жуулчлалын "Улаанбаатар брэнд"-ийг бий болгож, гадаад, дотоодын жуулчдад зориулсан соёл, урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлнэ.

2.4.6. Дэлхийн Бүтээлч хотуудын сүлжээнд нэгдсэн 350 гаруй хотуудтай хамтран ажиллах "Бүтээлч хот" зорилтот төслийг хэрэгжүүлж, гар урлал, кино урлаг, хөгжим, уран бүтээл, хоол үйлдвэрлэл, дизайн зэрэг бүтээлч салбаруудын эдийн засгийг тэлнэ.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

2.5. Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжиж, идэвхтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангийн "Хүүхдэд ээлтэй хот" санаачилгыг дэмжинэ.

2.5.1. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг нутаг дэвсгэрийн нэгж бүрд төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлийн боловсрол олгох,



сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлж, хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.2.Нутаг дэвсгэрийн нэгж бүрд байх нийгмийн хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлж хүүхдийн хамгаалуулах эрхийг хангана.

2.5.3.Аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, хүүхдийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тэдгээрээс гарах санал санаачилгыг нутаг дэвсгэрийн Хүүхдийн төлөө зөвлөл, шийдвэр гаргах түвшинд хүргэж хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хангана.

2.5.4.Өсвөр үе, залуучуудын сөрөг зан үйл, хорт зуршил, цахим дээрэлхэлт, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

2.5.5.Залуучуудын сайн дурын, хүмүүнлэгийн ажил болон шийдвэр гаргах түвшинд оролцох оролцоог дэмжиж, зорилтот бүлгийн залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэхэд хамтран ажиллана.

2.5.6.Төв цэнгэлдэх хүрээлэнг 4 улирлын турш ашиглах боломжтой, орчин үеийн спорт цогцолбор, амралт чөлөөт цагийн төв болгон хөгжүүлж, залуучуудын спорт, соёлын арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Хотын эдийн засгийн суурийг бэхжүүлж, төсвийн бус эх үүсвэрээр хөрөнгө оруулалтыг бүрдүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.

Санхүү, хөрөнгө оруулалтын бодлого

3.1 Нийслэлийн эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсвийн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.

3.1.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төсвийн худалдан авалтыг эдийн засгийн нөөц, улирлын онцлогт нийцүүлэн төлөвлөх замаар төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлнэ.

3.1.2.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг хиймэл оюун ухаанд суурилан оновчтой тодорхойлж, хөгжлийн бүтээн байгуулалтад чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.


3.1.3.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн зардал, үр ашгийн тооцоолол хийж, эдийн засгийн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Төсвийн санхүүжилтийн шинэ эх үүсвэр

3.2.Улаанбаатар хотын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлж, татварын хамрагдалт, өмчийн ашиглалтыг сайжруулна.

3.2.1.Гадаад, дотоодын зах зээлд нийслэлийн үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авч өрийн удирдлагын зохистой бодлогыг хэрэгжүүлэх замаар Улаанбаатар хотын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.

3.2.2.Нэн тэргүүн ээлжид шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.



3.2.3.Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлж татварын бодлогын тогтвортой байдлыг хангана.

3.2.4.Төсвийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын орлогыг нэгдсэн системд бүртгэлжүүлж, ил тод байдлыг хангах замаар хяналтыг сайжруулна

